



БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

“Монгол улсын хууль, тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” батлах тухай Монгол Улсын Их хурлын 2017 оны 0,1 дүгээр сарын 12-ны өдрийн 11 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлийн 3.33 дахь хэсэгт Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хариуцан боловсруулж, 2017 онд багтаан Улсын их хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан байна.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн үндсэн зорилго нь хаягдал усан дахь бохирдлыг үе шаттай бууруулж улмаар байгаль орчинд учруулж буй сөрөг нөлөөллийг багасгах, усыг зүй зохистой дахин ашиглах, үүнд чиглэсэн техник технологийг нэвтрүүлэх, тэдгээрийг эдийн засгийн урамшууллын хөшүүргээр дэмжих явдал юм.

Гэвч 2012 оны 05 дугаар сарын 17-нд батлагдсан Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль өнөөдрийг хүртэл хэрэгжихгүй царцсан байдалтай байгаа нь уг хуулийн зарим зохицуулалтыг эргэн харах, холбогдох зүйл заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагыг бий болгосон. Иймээс уг хуулийг үндсэн зорилго чиглэлд нь нийцүүлэн ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үр нөлөөний үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын дагуу хийлээ.

ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүнийг дагаж өөрчлөгдөх Усны тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үр нөлөөг үнэлэх шалгуурт дараахь үзүүлэлтүүдийг авч үзэх нь зүйтэй гэж үзсэн болно. Үүнд:

- Зорилгод хүрэх байдал
- Ойлгомжтой байдал
- Хүлээн зөвшөөрөгдөх байдал
- Зардал
- Харилцан уялдаа

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт 1. Шалгуур үзүүлэлт, шалгах арга зам

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 32 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
3	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийг хэрэгжүүлэх боломжтой эсэхэд шууд нөлөөлөх аж ахуйн нэгжүүд, хэрэгжүүлэх байгууллагуудын дунд хэлэлцүүлэг хийж үнэлэх.
4	Зардал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийн нөлөөллөөс иргэн аж ахуйн нэгж байгууллага, төрийн байгууллагад гарах нэмэгдэл зардлыг үнэлж тооцох.
5	Харилцан уялдаа	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.

2.1 ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

2.1.1 Зорилгодоо хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьлоо.

Монгол Улсын Үндсэн Хуулийн Арван зургаадугаар зүйлийн 2 дахь хэсэгт Монгол Улсын иргэн “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.1-т “Хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд сөрөг нөлөөгүй, үр ашигтай, дэвшилтэт технологи нэвтрүүлж, нөөцийг хэмнэх, эргүүлэн ашиглах, хаягдлыг дахин боловсруулан ашиглах ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ.”, 4.1.6-т “Хот,

суурин газрын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж, хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлнэ.”, 4.2.3-т “Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, хаягдал бохир усыг цэвэрлэн дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжинэ.”, 4.2.8-т “Байгаль орчинг хамгаалах, байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах чиглэлээр эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, ашиглалтын үр өгөөжийг сайжруулна.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 3 дугаар зүйлийн 3.33 дахь хэсэгт Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж 2017 онд өргөн мэдүүлэхээр заасан.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 03/03 тоот “Нийслэлийн агаар, орчны бохирдлын тухай” зөвлөмжийн 1.3-т “Агаар, орчны бохирдлыг бууруулах, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар төрийн бүх шатны байгууллага, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний хүлээх үүрэг хариуцлагын тогтолцоог бий болгох эрх зүйн орчинг бүрдүүлэх.” гэж зөвлөмж болгосон.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулсан.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төслийн зохицуулалтыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийсэн. Үүнд:

	Хуулийн төслийн үзэл баримтлал	Хуулийн төслийн зохицуулалт			
1	Зорилт 1. Ус бохирдуулагчийг төлбөрөөс чөлөөлж, хөнгөлөх зохицуулалтыг илүү тодорхой болгох зорилгоор хаягдал усыг цэвэрлэх байгууламж ашиглан хаягдал усны стандартын түвшинд хүртэл цэвэрлэж байгаа бол тодорхой хугацаагаар төлбөрөөс чөлөөлөх:	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “Хаягдал усыг цэвэрлэх байгууламж ашиглан хаягдал усны стандартын түвшинд хүртэл цэвэрлэж байгаа бол цэвэрлэх байгууламж суурилуулан ашигласан өдрөөс эхлэн гурван жилийн хугацаагаар.” чөлөөлнө гэж шинээр заалт нэмсэн нь хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангаж байна.			
2	Зорилт 2. Аж ахуйн нэгж, байгууллагад татварын хэт их дарамт үүсгэхгүй, нөгөө талдаа байгаль орчин, усны нөөцийг хамгаалах бодлого, эдийн	Хүчин төгөлдөр үйлчилж буй Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 7.1-д зааснаар Төлбөрийн хэмжээг дараах хязгаарт багтаан тогтооно: <table border="1" data-bbox="810 1966 1433 2036"> <tr> <td>Бохирдуулах бодис</td> <td>Хэмжих нэгж</td> <td>Төлбөрийн хязгаар</td> </tr> </table>	Бохирдуулах бодис	Хэмжих нэгж	Төлбөрийн хязгаар
Бохирдуулах бодис	Хэмжих нэгж	Төлбөрийн хязгаар			

засгийн хөшүүрэгтэй уялдуулан ус бохирдуулсны төлбөрийн доод хэмжээг 50-60 хувиар бууруулж, зөвхөн аюултай бохирдуулах бодисын доод хэмжээг өөрчлөлгүй хэвээр үлдээнэ.

		/төгрөгөөр/	
		доод	дээд
Жинлэгдэх бодис	килограмм	100	500
Органик бодис	килограмм	100	500
Эрдэс бодис	килограмм	50	200
Хүнд металл	килограмм	1000	5000
Аюултай бохирдуулах бодис	грамм	1000	5000

гэж заасныг хуулийн төсөлд 7.1.Төлбөрийн хэмжээг хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээнд үндэслэн дараах хязгаарт багтаан Засгийн газар тогтооно:

Бохирдуулах бодис	Хэмжих нэгж	Төлбөрийн хязгаар /төгрөгөөр/	
		доод	дээд
Жинлэгдэх бодис	килограмм	50	1000
Органик бодис	килограмм	50	1000
Эрдэс бодис	килограмм	20	400
Хүнд металл	килограмм	500	10000
Аюултай бохирдуулах бодис	грамм	1000	10000

гэж тусгасан. Ус бохирдуулсны төлбөр болон нөхөн төлбөр 2012 оны хуулиар жилд дунджаар 9 тэрбум төгрөг байсан бол нэмэлт, өөрчлөлтөөр төлбөрийн доод хэмжээг багасгаж ус бохирдуулсны төлбөр болон ус бохирдуулсны нөхөн төлбөр 3.9 тэрбум төгрөг болох судалгаа хийгдсэн нь хуулийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангаж байна.

Төлбөрийн дээд хязгаарыг тухайн үеийн улс орны эдийн засаг, нийгмийн суурь нөхцөлөөс хамааруулан Засгийн газрын бодлогоор зохих хугацааны дараа хэрэглэх бөгөөд хэрвээ дээд хязгаараар тооцвол Цэвэрлэх байгууламжууд ус бохирдуулсны болон нөхөн төлбөрт жилд 76.6 тэрбум төгрөг төлөх тооцоо гарч байгаа нь үйлчилгээний жилийн орлогоос

		<p>2.3 дахин өндөр байна. Энэ нь дээд хязгаарыг одоогийн нөхцөлд хэрэглэх боломжгүй байгааг харуулж байна.</p>
<p>3</p>	<p>Зорилт3. Төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгох үүднээс олон улсын туршлагад үндэслэн хаягдал усыг зохих журмын дагуу байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй ус бохирдуулсны төлбөр ногдуулах гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавих эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.</p>	<p>Усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага буюу Усны газрыг 2012 онд татан буулгасан. Үүнтэй холбоотой дараах өөрчлөлтүүдийг хийсэн.</p> <p>1.Хүчин төгөлдөр үйлчилж буй Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 4.2-т “Усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, эсхүл сав газрын захиргаа ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг харьяалах татварын албанд зөвшөөрөл олгосон өдрөөс хойш нэг сарын дотор гаргаж өгөх бөгөөд татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэж авна”. гэж заасныг Хуулийн төслийн 3 дугаар зүйлд “Сав газрын захиргаа, эсхүл сум, дүүргийн Засаг даргатай ус бохирдуулсны төлбөр ногдуулах гэрээ байгуулсан хот, суурин газрын ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэдэг хуулийн этгээд нь ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг харьяалах татварын албанд хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгосон өдрөөс хойш нэг сарын дотор гарган өгч, татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэж авна.” гэж өөрчлөн найруулсан.</p> <p>2.Хүчин төгөлдөр үйлчилж буй “Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн 9.2.3.татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төлбөрийн нэгдсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор гаргаж, усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ”. Мөн “9.3.Төлбөрийн тайлангийн маягтын загварыг татварын болон усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хамтран батална” гэж заасныг</p> <p>9.2.3.”татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага төлбөрийн</p>

		<p>нэгдсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дотор гаргаж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ”.</p> <p>9.3.”Төлбөрийн тайлангийн маягыг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална”. гэж өөрчлөн найруулсан.</p> <p>Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд зааснаар: Сав газрын захиргаа, эсхүл сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 4.2-т зааснаас бусад ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг харьяалах татварын албанд хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгосон өдрөөс хойш нэг сарын дотор гарган өгч, татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэж авна.”гэсэн заалт нэмсэн нь хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангаж байна.</p> <p>Мөн Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Сав газрын захиргааны бүрэн эрхэд хаягдал усыг зохих журмын дагуу байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй ус бохирдуулсны төлбөр ногдуулах гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах;” гэсэн заалт нэмсэн нь хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангаж байна.</p>
<p>4</p>	<p>Зорилт 4. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ стандартаас давсан тохиолдолд нөхөн төлбөр төлдөг хуулийн зохицуулалттай байдаг. Тэгвэл хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг шатлан бууруулах механизмыг бий болгож, бохирдлын хэмжээг стандарт руу ойртуулах бүрт нөхөн төлбөрийн хэмжээ дагаад буурах зарчмыг суулгаж, хаягдал усаа цэвэрлэн, бохирдуулах бодисын хэмжээг бууруулж</p>	<p>Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн “17.1.13” дахь заалтын дугаарыг “17.1.14” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “гурав дахин” гэснийг “хоёроос тав дахин шатлан өсгөх хэлбэрээр” гэж тус тус өөрчлөхөөр тусгасан нь хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангаж байна.</p>

	байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжих бодлогыг ус бохирдуулсны нөхөн төлбөрөөр дамжуулан бий болгоно.	
5	Зорилт 5. Усны чанарыг үнэлэх, шинжлэх аргачлал, зааврыг батлах зохицуулалтыг бий болгож салбарын хэмжээнд усны чанарыг үнэлэх нэгдсэн арга зүйгээр хангагдах нөхцөлийг бүрдүүлнэ.	Усны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсгийн “хөтөлбөрийг” гэснийг “хөтөлбөр, усны шинжилгээний аргачлалыг” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “усны хяналт-шинжилгээ хийх” гэснийг “усны хэрэглээний норм тогтоох, усны чанарыг бохирдлын индексээр үнэлэх” гэж усны чанарыг бохирдлын индексээр үнэлэх заавар, усны шинжилгээний аргачлалыг батлах эрхийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад олгохоор тусгасан.

2.1.2 Ойлгомжтой байдал

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүнийг дагаж өөрчлөгдөх Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн боловсруулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 32 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангаж байна гэж үзсэн.

Хуулийн төслүүд нь “Хууль тогтоомжийн тухай” хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-т зааснаар “хуульд өөрчлөлт оруулах” хуулийн төслийн хэлбэрээр бичигдсэн 5 зүйлтэй, хуулийн төслийн бүтцийн дугаарлалт хуульд заасан шаардлагыг хангасан байна.

Мөн төслийн бичилтийн хэлбэр нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 (Хуульд оруулах өөрчлөлтийг зөвхөн нэг хуульд хамааруулж хийх бөгөөд өөрчлөлт орж байгаа хуулийн нэр, зүйл, хэсэг, заалтын дугаарыг тодорхой бичнэ), 24.7 (Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төсөлд зүйлийн гарчиг тавилгүйгээр зүйлийн агуулгыг дугаарын хойноос шууд бичнэ), 24.8 (Хуулийн нэг зүйлд хэд хэдэн өөрчлөлт оруулж байгаа бол өөрчлөлт тус бүрийг бие даасан заалт болгон тэмдэглэнэ), 24.9 (Өөрчлөлт оруулж байгаа зүйл, хэсэг, заалтын зарим нэр томьёо, үг хэллэгийг өөрчилсөн буюу хассанаар түүний утга агуулга нэг мөр ойлгогдохооргүй байвал түүнийг өөрчлөн найруулна) дэх хэсэгт заасантай нийцэж байна.

Түүнчлэн бие даасан санаа бүрийг тусгай зүйлд тусгаж, заалт нь нэг өгүүлбэрээр илэрхийлэгдсэн, мөн хуулийн 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгын нийтлэг шаардлагад нийцсэн байна.

Хуулийг дагаж мөрдөх хугацааг тусгайлан заах шаардлагатай эсэхийг тодруулах, эсхүл тухайн хуулийг баталсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлд зааснаар албан ёсоор нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болохоор зохицуулсан тул хуульд заасныг давхардуулан заахгүй байх нь зүйтэй юм.

Хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтийн ойлгомжтой байдлыг холбогдох газруудаар 10 удаа хэлэлцүүлж, сургалт, семинарт танилцуулсан. Үүнд:

- УСУГ-ын удирдлага, инженер техникийн ажилтнууд, мэргэжилтнүүд
- Туул голын сав газрын захиргааны удирдлага, мэргэжилтнүүд
- Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооны удирдлага, гишүүд
- Ногоон парламент байгууллагын гишүүд
- “Туул голын сав газрын захиргаа болон зөвлөлийн хамтын ажиллагааг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж шийдвэрлэх нь” уулзалт,
- Улаанбаатар Ус-Технологи 2017” эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурал
- “Усны чанарын хяналт шинжилгээ, менежмент” сэдэвт Сав газрын захиргаа болон аймгийн Байгаль орчны хэмжил зүйн лабораторийн мэргэжилтнүүдэд зориулсан бүсчилсэн сургалт (Зүүн бүс)
- “Усны чанарын хяналт шинжилгээ, менежмент” сэдэвт Сав газрын захиргаа болон аймгийн Байгаль орчны хэмжил зүйн лабораторийн мэргэжилтнүүдэд зориулсан бүсчилсэн сургалт (Баруун бүс)
- Говийн сав газарт үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудын төлөөлөл
- БОАЖ-ын Сайдын зөвлөлийн хурал

Хэлэлцүүлгээс харахад хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлт нь хуулийг хэрэгжүүлэх төрийн байгууллага, ус бохирдуулсны төлбөр төлөх аж ахуйн нэгжийн төлөөллүүдэд ойлгомжтой болсон талаар саналаа илэрхийлсэн байна.

2.1.3 Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтөөр Сав газрын захиргаа, эсхүл сум, дүүргийн Засаг дарга нь улсын болон аймгийн зэрэглэлтэй хот, суурин газрын ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэдэг хуулийн этгээдтэй ус бохирдуулсны төлбөр ногдуулах гэрээ байгуулахаар тусгагдсан.

Хот, суурин газрын ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэдэг хуулийн этгээдийн төлөөлөл болгож Ус сувгийн удирдах газрын удирдлага мэргэжилтнүүдэд хуулийн төслийг танилцуулж, хэлэлцүүлэг хийсэн. Хуулийн этгээд нь ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг харьяалах татварын албанд хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгосон өдрөөс хойш нэг сарын дотор

гарган өгч, татварын алба уг мэдээллийг үндэслэн төлбөр төлөгчийг бүртгэж авна.

Усны тухай хуулийн 24.2-т “Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг хоногт 50 шоометрээс их, эсхүл энэ хуулийн 10.1.12-д заасан аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн сав газрын захиргаа, хоногт 50 шоометрээс бага хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоно” гэж заасан байдаг тул энэ заалттай уялдуулан найруулсан.

Хуулийг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын чиг үүрэг тодорхой бус байсныг олон улсын туршлагад үндэслэн хаягдал усыг байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй ус бохирдуулсны төлбөр ногдуулах гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавих эрхийг сав газрын захиргаанд олгохоор шинээр тусгасан нь хуулийг хэрэгжих үндсэн суурь нөхцөлийг бий болгосон гэж үзэж байна.

Хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтийн үр дагаварт шууд хамаарах Ус сувгийн удирдах газрын удирдлага, мэргэжилтнүүд болон Сав газрын захиргаадын мэргэжилтнүүдийн дунд хэлэлцүүлэг хийсэн.

- УСУГ-ын удирдлага, инженер техникийн ажилтнууд, мэргэжилтнүүд
- Туул голын сав газрын захиргааны удирдлага, мэргэжилтнүүд
- Сав газрын мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулсан “Туул голын сав газрын захиргаа болон зөвлөлийн хамтын ажиллагааг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж шийдвэрлэх нь” уулзалт,
- Сав газрын захиргаа болон аймгийн Байгаль орчны хэмжил зүйн лабораторийн мэргэжилтнүүдэд зориулсан бүсчилсэн сургалт (Зүүн бүс)
- Сав газрын захиргаа болон аймгийн Байгаль орчны хэмжил зүйн лабораторийн мэргэжилтнүүдэд зориулсан бүсчилсэн сургалт (Баруун бүс)

Аж ахуйн нэгжүүдтэй шууд гэрээ байгуулан ажиллах УСУГ болон Сав газрын захиргаадын удирдлага, мэргэжилтнүүд зарчмын хувьд хүлээн зөвшөөрч байгаагаа илэрхийлсэн санал өгсөн.

Хэлэлцүүлгийн үед гарсан саналыг хуулийн төсөлд тусгасан. Тухайлбал, Усны тухай хуулийн 17 дугаар зүйлд “Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй иргэн, аж ахуйн нэгж байгууллага болон байгальд хаягдал ус нийлүүлж буй цэвэрлэх байгууламжуудад хаягдал ус хаях зөвшөөрөл олгож, гэрээ байгуулан, хяналт тавьж ажиллах” тухай эрх үүргийг нэмэлтээр тусгах нь зүйтэй гэсэн санал гаргасан.

Сав газрын захиргаанд хаягдал усыг зохих журмын дагуу байгальд шууд нийлүүлж байгаа хуулийн этгээдтэй ус бохирдуулсны төлбөрийн гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллах эрхийг хуулиар олгохоор тусгасан.

2.1.4 Зардал

Төрд үүсэх зардал:

Зардлын тооцооны тайлангаас харахад Сав газрын захиргаад эсвэл сум, дүүргийн Засаг дарга цэвэрлэх байгууламжуудтай болон байгальд шууд хаягдал ус нийлүүлж байгаа аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулах, цэвэрлэх байгууламжууд ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг татварт гаргаж өгөхийг ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтөд;

Аймаг, нийслэлийн байгаль орчны газар хүний үйл ажиллагааны улмаас элэгдэл, эвдрэлд орж, ашиглалтгүй орхигдсон газрыг өөрийн хүч, хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дүгнэлт гаргахаар тус тус тусгасан нь төрийн хүний нөөцийн ачаалал бага зэрэг үүсгэх ба нэмэлт, зардал гаргахгүйгээр шийдвэрлэх боломжтой гэж үзлээ.

Иргэнд үүсэх зардал:

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Засгийн газрын холбогдох тогтоолоор хүн ам ус бохирдуулсны төлбөрөөс чөлөөлөгдөхөөр байна. Энэ нь тэдний бохир усны зардалд шууд нөлөө үзүүлэхгүй.

Иргэн, аж ахуйн нэгжид:

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд нэмэлт өөрчлөлт орж байгаа Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр иргэн, аж ахуйн нэгжид зардал үүснэ. /Зардлын тооцоо хэсэгт оруулсан./

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар аж ахуйн нэгжид нэмэлт зардал үүсэхгүй.

Ус бохирдуулсны төлбөрийн доод хэмжээг хуулийн төсөлд зааснаар умбуур бодис болон органик бодис 50 төг/кг, эрдэс бодис 20 төг/кг, хүнд металл 500 төг/кг болгон бууруулснаар ус бохирдуулсны төлбөр төлөх аж ахуйн нэгжид учрах дарамтыг 2-2.5 дахин бууруулах юм.

2.1.5 Харилцан уялдаа

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ.

- *Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх: Тийм*

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 4.10-т заасан асуултад хариулах замаар харилцан уялдааг үнэлэв. Үүнд:

Д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	4.10.1.хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Тийм	
2	4.10.2.хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Мөн	
3	4.10.3.хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Тийм	
5	4.10.4 Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Тийм	
6	4.10.5.хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Үгүй	
7	4.10.9.төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Боломж бага	
8	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Тийм	Хуулийн төсөлд тусгагдсан БОАЖЯ, БХБЯ, Сав газрын захиргаадын гүйцэтгэх үүрэг тодорхой болсон гэж үзэж байна.
9	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй	
10	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй	
11	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Үгүй	

12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд иргэдийн эрхийг хязгаарласан ямар нэгэн нэмэлт зохицуулалт тусгадаагүй байна.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Тийм	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Өрсөлдөөний тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.
15	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тийм	Тухайн хуулийн зохих заалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Зөрчлийн хууль, Төрийн албаны тухай хуультай нийцүүлэн, холбогдох хуулиар зохицуулна.

Дээрх судалгаанаас үзэхэд Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбогдуулан Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд нь бусад хууль тогтоомжтой уялдсан, асуудал давхардаагүй байна.

2.1.6 Үр дүнгийн үнэлгээ, зөвлөмж, олон улсын туршлага

Олон улсын туршлага: Ус бохирдуулсны төлбөрийг бохирдуулагч бодисын хэмжээгээр, бохир усны хэмжээгээр болон бүтээгдэхүүн үйлчилгээнд ногдуулах замаар авдаг. Эдгээрээс хамгийн өргөн хэрэглэгддэг арга нь бохирдуулах бодисын хэмжээнд төлбөр ногдуулах арга юм.

Олон улсын практикаас үзэхэд бохирдуулсны төлбөрийг Бохирдуулагч өөрийн гаргаж буй бохирдлоо хянаж, бууруулахад нөлөө үзүүлэхүйц өндөр тогтоогддог байна. Бохирдсон, хаягдал усыг нийтийн эзэмшлийн усан орчин болон газрын доорх усанд нийлүүлж байгаа ариутгах татуургын байгууллагууд, компаниудад стандартаас давсан тохиолдолд торгууль хэлбэрээр нөхөн төлбөр ногдуулдаг.

Олон улсын жишгээр бохир усыг шууд болон цэвэрлэж байгальд нийлүүлж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс бохирдуулсны төлбөрийг авдаг байна.

ОХУ, Казахстан зэрэг газарт үйл ажиллагааны явцдаа усанд ямар нэг бодис хийсэн тохиолдолд төлдөг. Айл өрх чөлөөлөгдсөн. Стандартаас доогуур бол бодисын хэмжээнээс хамаарна, дээш гарвал түүнээс 3-5 дахин их, зөвшөөрөгдөх дээд хязгаараас давбал үүнийг торгууль маягаар дахин 3-5 дахин нугалж төлдөг байна. ОХУ-д уг төлбөрийн хэмжээг 1992 оноос мөрдүүлж, төлбөрийн зохицуулалтыг нутгийн захиргааны байгууллага (хотын Мэр) тогтоодог. Тухайлбал, Москва хотын захирагчийн тушаалаар бүх төрлийн орон сууцны оршин суугчдыг ус бохирдуулсны төлбөрөөс чөлөөлдөг байна.

Түүнчлэн Чех, Хятад, АНУ, Киргиз зэрэг орнуудын ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, тогтоомжуудтай танилцахад Чех улсын усны хуульд ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гаргаж буй хаягдал усны эзлэхүүн болон бохирдолд төлбөр ноогдуулдаг байна. Хаягдал усанд ногдуулах төлбөрийг нэг жилд 30000 м³-ээс давсан хаягдал усны 1м³ эзлэхүүн тутамд 0,1 чех кронаар тооцон, хаягдал усны бохирдолд ногдуулах төлбөрийг хаягдал усан дахь ус бохирдуулах бодис тус бүрийн хэмжээнд тооцсон ус бохирдуулсны төлбөрийн нийлбэрээр тодорхойлдог байна. Хаягдал усанд агуулагдах ус бохирдуулах бодис тус бүрийн хэмжээг тухайн жилд ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хаяж буй хаягдал усны эзлэхүүнийг ус бохирдуулах бодис тус бүрийн жилийн дундаж агууламжаар үржүүлж тооцдог байна.

Чех улсад үйлдвэрийн хаягдал усны стандартаар үйлдвэрүүдээс гарч буй хаягдал усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд агууламжийг үйлдвэрлэлийн салбар, үйлдвэрийн үйл ажиллагааны төрөл, онцлогоос хамааруулан ялгаатай тогтоодог байна. Жишээлбэл: хаягдал усан дахь органик бодисыг илэрхийлэгч химийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрийн хувьд 200мг/л, сүүний үйлдвэрт 120 мг/л гэж тус тус заажээ.

Хятад улсын байгаль хамгаалах хуульд хаягдал усны стандартаас давсан бохирдолтой хаягдал ус гаргаж буй ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хаягдал усны эзлэхүүн болон стандартаас давсан бохирдуулах бодис тус бүрийн агууламжаас хамааруулан нөхөн төлбөр тооцохоор заасан байдаг. Хятад улсад үндэсний болон орон нутгийн түвшинд мөрдөгдөх хаягдал усны стандарт өөр өөр байх бөгөөд орон нутгийн түвшинд хаягдал усны стандарт нь үйл ажиллагаа явуулж буй үйлдвэр, үйлчилгээний газрын үйл ажиллагааны төрөл онцлогоос хамааруулан үндэсний стандартад тусгагдаагүй бодисын төрлүүд болон тэдгээрийн зөвшөөрөгдөх дээд агууламжийг илүү хатуу тогтоож өгдөг.

АНУ-ын хувьд хүн амын тоо, зонхилж буй үйлдвэрүүд болон тэдгээрийн хүчин чадал, тухайн мужийн байгалийн нөхцөл байдлаас хамааран муж тус бүрт өөр өөр хаягдал усны стандарт мөрдөгддөг байна.

Нидерланд улсад бохирдуулагч нэгжийг тогтоон үл хөдлөх хөрөнгөд ногдуулан авч байна. Герман улсад бохирдлын төлбөр нь бохирдлоос урьдчилан сэргийлэх зориулалттай эсвэл байгаль хамгаалах арга хэмжээнд зориулж төлбөр авдаг /Экосистемийн үйлчилгээний төлбөр/. Франц улсад бохир ус нийлүүлсний төлбөр болон бохир ус цэвэрлэсний зардлыг багтааж авдаг байна. Бохирдуулагчаас хураасан төлбөрөөр ус цэвэрлэх байгууламжуудаас гадна усан орчны чанарын хяналт тавьдаг байгууллагуудыг санхүүжүүлдэг.

ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ, ЗӨВЛӨМЖ:

Энэхүү үр нөлөөг тооцох үнэлгээг Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, түүний үзэл баримтлал, түүнийг дагаж өөрчлөгдөх Усны тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдэд тус тус боловсруулсан болно.

Хуулийн төслүүд дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хэрэгжих боломж, хүлээн зөвшөөрөгдөх байдал, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх, зардал гэсэн шалгуур үзүүлэлтүүдээр хийсэн үнэлгээг нэгтгэн дараах дүгнэлтийг хийлээ.

ДҮГНЭЛТ:

Зорилгодоо хүрэх байдал: Хуулийн төслийн зохицуулалт нь төслийн үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг бүрэн хангаж байна гэж үзэж байна. Цаашид ус бохирдуулсны төлбөр, нөхөн төлбөрийн асуудал болон бусад холбогдох харилцааг журамд илүү нарийвчлан тусгаж өгөх шаардлагатай.

Ойлгомжтой байдал: Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг агуулга, хэлбэрийн хувьд хангасан, ойлгомжтой болсон байна.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал: Шууд нөлөөлөл үзүүлэх этгээдүүдийн дунд хийсэн санал асуулга, хэлэлцүүлгийн дүнд зарчмын хувьд хэрэгжих боломжтой нь тогтоогдсон.

ЗӨВЛӨМЖ: Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг зохих журмын дагуу хийж гүйцэтгэн дараахь зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Нэг. Хууль батлагдсантай холбогдуулан дагалдан гарах Засгийн газрын тогтоол; төрийн захиргааны төв байгууллагын дүрэм, журмуудыг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

- Төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх аж ахуйн нэгж байгууллагын жагсаалт болон хөнгөлөлтийн хувь хэмжээг тогтоох тухай Засгийн газрын

тогтоолын төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанд оруулж, батлуулах;

- Ахуйн хэрэгцээнээс гарч байгаа хаягдал уснаас төлбөр авах журмын төслийг боловсруулж Засгийн газраар батлуулах шаардлагатай боловч, ард иргэдийн нуруун дээр буух татварын дарамтыг нэмэгдүүлэх нь цаг хугацааны хувьд тохиромжгүйг анхаарах.
- Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийн бичгийн загварыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлуулах;
- Байгаль орчин, аялал жуучлалын болон Сангийн сайд нарын 2015 оны А-299/204 тоот “Журам, аргачлал батлах тухай” хамтарсан тушаалыг шинэчлэн боловсруулж батлуулах;
- Байгаль орчин, аялал жуучлалын сайдын 2015 оны А-294 тоот “Жагсаалт батлах тухай” тушаалыг шинэчлэх.

Хоёр. Хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулснаар хоёрдмол утгатай зүйл заалтыг хооронд нь нийцүүлэх, ойлгомжгүй нэр томъёог залруулах, тунхаглалын шинжтэй байсан төлбөрөөс чөлөөлөх зохицуулалтыг илүү тодорхой болгох, ус бохирдуулагчтай гэрээ байгуулах асуудлыг олон улсын жишигт нийцүүлэн шинээр тусгах зэрэг зарчмын шинжтэй томоохон өөрчлөлтүүдийг оруулсан байна. Хэдий тийм боловч ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгжийг бүртгэх, төлбөр хураамжийг цуглуулах, тайлан мэдээ гаргах, ус бохирдуулагчдын мэдээллийн сан үүсгэх зэрэг хууль хэрэгжих явцад гарч болох хүндрэлтэй асуудал байгааг анхаарч, ялангуяа татварын алба, орон нутгийн эрх бүхий байгууллага болон хуулийн этгээдийн хоорондын хамтын ажиллагааг сайжруулахад Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бодлогоор дэмжлэг үзүүлэх;

Гурав. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахын тулд хуулийг олон нийтэд сурталчлан таниулах, хуулийн үйлчлэлд хамаарах ус бохирдуулагчид холбогдох мэдлэг, мэдээллийг тухай бүр хүргэх, мөн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх төрийн байгууллагын ажилтан, албан хаагч нарт сургалт, семинарыг тогтмол зохион байгуулах нь зүйтэй.

ГУРАВ. УС БОХИРДУУЛСНЫ ТӨЛБӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО

Энэхүү тооцоог Монгол улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан. Үүнд:

- Хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах

3.1 Хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулснаар төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардал

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулснаар төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр нэг албан хаагчид шаардагдах зардлаар үржүүлэн тооцох замаар дараахь үе шаттайгаар гаргана. Үүнд:

- Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох
- Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хугацааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг тогтоох
- Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох
- Бусад зардлал буюу материаллаг зардлыг нэгтгэн тооцох
- Хувилбарыг нягтлах

Нэгдүгээр үе шатны хүрээнд:

Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг нэг бүрчлэн түүвэрлэн, хийж гүйцэтгэх үйл явцын дагуу уялдаа холбоог харгалзан тодорхойлсон. Ийнхүү тодорхойлохдоо ажил үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулах нь зүйтэй. Үүнд:

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт

- **Сав газрын захиргаа, эсхүл сум, дүүргийн Засаг дарга** нь улсын болон аймгийн зэрэглэлтэй хот, суурин газрын ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэдэг хуулийн этгээдтэй бохирдуулсны төлбөр ногдуулах гэрээ байгуулах

- **Улсын болон аймгийн зэрэглэлтэй хот, суурин газрын ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэдэг хуулийн этгээд** нь ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг харьяалах татварын албанд хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгосон өдрөөс хойш нэг сарын дотор гарган өгөх
- Улсын болон аймгийн зэрэглэлтэй хот, суурин газрын ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэдэг хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгжтэй ус бохирдуулсны төлбөр ногдуулах гэрээ байгуулсан **сум, дүүргийн Засаг дарга** ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг харьяалах татварын албанд гаргахаар тус тус тусгасан.

Газрын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт

- Аймаг, нийслэлийн байгаль орчны газрын дүгнэлт гаргахаар тусгасан

Хоёрдугаар шатны хүрээнд:

Төрийн үүрэг буюу ажил үйлчилгээг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой гэрээ байгуулах, татварт тайлагнахтай холбоотой дараах ажлууд хамаарч байна.

Үүнд:

- Сав газрын захиргаа, сум, дүүргийн Засаг дарга Цэвэрлэх байгууламжтай гэрээ байгуулах (Одоогийн байдлаар Монгол улсын хэмжээнд нийт 130 ЦБ ажиллаж байгаагаас бүрэн ажиллагаатай нь 56, хагас ажиллагаатай нь 27, ажиллагаагүй 47 байна. Улсын хэмжээнд ажиллаж байгаа 29 Сав газрын захиргаа нь эдгээр ЦБ-тай гэрээ байгуулж ажиллах шаардлагатай болох юм.) Бүх аймгуудад сав газрын захиргаадын төлөөлөл байрладаг ба орон нутагт сум дүүргийн Засаг дарга гэрээ байгуулна.
- Гэрээ байгуулсан улсын болон аймгийн зэрэглэлтэй хот, суурин газрын ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэдэг хуулийн этгээд ус бохирдуулагчдад хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл олгох, мэдээллийг татварын албанд гарган өгөх
- Сав газрын захиргаа эсхүл сум, дүүргийн Засаг дарга цэвэрлэх байгууламжаар дамжуулахгүй шууд байгальд нийлүүлж буй аж ахуйн нэгжтэй ус бохирдуулсны төлбөр ногдуулах гэрээ байгуулах, мэдээллийг харьяалах татварын албанд гаргах
- Аймаг, нийслэлийн байгаль орчны газар дүгнэлт гаргах

Үйл ажиллагаа бүрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд задлан, уг арга хэмжээг хэрэгжүүлэхэд хийгдэх алхам бүрээр гарган зарцуулах хугацааг тодорхойлов.

	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Давтамж /жилд 1 удаа	Хүний нөөцийн хэрэгцээ/мин
1.	Сав газрын захиргаа эсвэл сум, дүүргийн Засаг дарга нь цэвэрлэх байгууламжтай гэрээ байгуулах /Сав газрын захиргаа эсвэл сум, дүүргийн Засаг дарга жилдээ 1-2 цэвэрлэх байгууламжтай гэрээ байгуулна/.	ЦБ-тай байгуулах гэрээний нөхцлийг боловсруулах	1/240мин	1 удаа	240
		Гэрээг хуулийн мэргэжилтэн хянах	1/15мин	1 удаа	15
		Гэрээг эцэслэн байгуулах	1/60мин	1 удаа	60
		Гэрээний хэрэгжилтэд хяналт хийх	1/480	4удаа	1920
		Гэрээг дүгнэх	1/240	1 удаа	240
2	Гэрээ байгуулсан цэвэрлэх байгууламж нь ус хаях, зайлуулах зөвшөөрлийг ус бохирдуулагчдад олгох, мэдээллийг татварт гарган өгөх	Ус хаях, зайлуулах зөвшөөрлийн маягт бөглөх	1/9600	1 удаа	9600
		Мэдээллийг нягтлах, баталгаажуулах	1/9600	1 удаа	9600
		Мэдээллийг татварт өгөх	1/4800	1удаа	4800
3	Сав газрын захиргаа эсхүл сум, дүүргийн Засаг дарга цэвэрлэх байгууламжаар дамжуулахгүй шууд байгальд нийлүүлж буй аж ахуйн нэгжтэй ус бохирдуулсны төлбөр ногдуулах гэрээ байгуулах, мэдээллийг харьяалах татварын албанд гаргах	Гэрээний нөхцлийг судлах, боловсруулах	1/4800	1 удаа	4800
		Гэрээг хуулийн мэргэжилтэн хянах	1/300	1 удаа	300
		Гэрээг эцэслэн байгуулах	1/1200	1 удаа	1200
		Гэрээний хэрэгжилтэд хяналт хийх	1/9600	4 удаа	38400
		Гэрээг дүгнэх	1/4800	1 удаа	4800
		Татварт мэдээлэл өгөх	1/1200	1 удаа	1200
4	Хүний үйл ажиллагааны улмаас элэгдэл, эвдрэлд орж, ашиглалтгүй орхигдсон газрыг өөрийн хүч, хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад аймаг, нийслэлийн байгаль орчны газар дүгнэлт гаргах	Албан бичиг, бусад материалтай танилцах	1/19200	1 удаа	19200
		Дүгнэлт бичих	1/9600	1 удаа	9600
		Дүгнэлтийг хянах, баталгаажуулах	1/2400	1 удаа	2400

Ийнхүү үйл ажиллагаа тус бүр зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж, уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг гаргалаа.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо
Сав газрын захиргаа эсвэл Сум, дүүргийн Засаг дарга	53175мин	96000	0.55
Улсын болон аймгийн зэрэглэлтэй хот, суурин газрын ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэдэг байгууллагууд	24000 мин	96000	0.25
Аймаг, нийслэлийн байгаль орчны газар	31200мин	96000	0.32

Сав газрын захиргаа эсвэл сум дүүргийн Засаг дарга улсын болон аймгийн зэрэглэлтэй хот, суурин газрын ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэдэг хуулийн этгээдтэй болон цэвэрлэх байгууламжаар дамжуулахгүй шууд байгальд нийлүүлж буй аж ахуйн нэгжтэй ус бохирдуулсны төлбөр ногдуулах гэрээ байгуулах, мэдээллийг татварт гаргаж өгөхөд 886 цагийн ачаалал үүсч байгаа бөгөөд тухайн ажлыг гүйцэтгэхэд 0.55 хүн шаардлагатай байна.

Улсын болон аймгийн зэрэглэлтэй хот, суурин газрын ахуйн болон үйлдвэрийн хаягдал усыг цэвэрлэдэг байгууллагууд нь ус бохирдуулагч аж ахуйн нэгжүүдэд зөвшөөрлийн бичиг олгож, мэдээллийг татварт өгөхөд 400 цагийн ачаалал үүсч байгаа бөгөөд тухайн ажлыг гүйцэтгэхэд 0.25 хүн шаардлагатай байна.

Аймаг, нийслэлийн байгаль орчны газар хүний үйл ажиллагааны улмаас элэгдэл, эвдрэлд орж, ашиглалтгүй орхигдсон газрыг өөрийн хүч, хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дүгнэлт гаргахад 520 цагийн ачаалал үүсч байгаа бөгөөд тухайн ажлыг гүйцэтгэхэд 0.32 хүн шаардлагатай байна.

Иймээс дээрх ажлыг гүйцэтгэхэд хүний нөөцийн хэрэгцээ шаардлага бий болохгүй нь харагдаж байна.

Гуравдугаар үе шатны хүрээнд: Зардлын тооцоог хүний нөөцийн, материаллаг, бусад гэсэн зардлын мэдээллийн үндсэн дээр гаргадаг бөгөөд ажиллах шаардлагатай хүний нөөцтэй тэдгээр зардлын оногдох хэсгүүдийн нийлбэрээр уг зардлыг тооцно.

Дээрх гаргасан хүний нөөцийн хэрэгцээ шаардлага бий болсон тохиолдолд түүн дээр үндэслэн тухайлсан байгууллагуудын хувьд зардлыг тооцон гаргах боломжтой байсан. Манай тохиолдлын хувьд хувь хүний хэрэгцээ гаргаагүй тул цалин болон бусад материаллаг зардлыг тооцох шаардлагагүй болно.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлтөөр орж байгаа үйл ажиллагааг зохион байгуулах Сав газрын захиргаад, сум, дүүргийн засаг дарга, улсын болон орон нутгийн чанартай төв цэвэрлэх байгууламж, аймаг нийслэлийн байгаль орчны газрууд хариуцан гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээг гаргаснаар тооцоолол дууслаа.

Дөрөвдүгээр үе шатны хүрээнд: Нийт дүнг тооцоолох бөгөөд хүний нөөцийн зардал, материаллаг зардал, бусад зардлын нийлбэрээр нийт зардлыг тооцон гаргана. Шаардлагатай албан хаагчийн хэрэгцээ өмнөх үе шатуудад тодорхой болсон тул энэ үе шатанд Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайлсан төрийн байгууллагын нэг төрийн албан хаагчид оногдох материаллаг зардлыг төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гэрээгээр гүйцэтгүүлэхэд төрийн төрийн байгууллагын зүгээс хийгдэх ажиллагааг гүйцэтгэх шаардлагатай хүний нөөцөөр үржүүлэх замаар гаргах боломжтой юм. Нэг албан хаагчид ногдох хүний нөөцийн болон материаллаг зардлын тогтоосон жишиг одоогоор байхгүй байгаа тул үүнийг ерөнхий байдлаар тооцоолох боломжгүй юм. Харин тухайлсан байгууллагын хувьд тооцоолон гаргах боломжтой.

Тавдугаар үе шатны хүрээнд: Хувилбарыг нягтлан хялбарчлах боломжийг шалгаж, үр дүнг танилцуулах ажлыг энэхүү үе шатанд хийж гүйцэтгэдэг. Дээрх тооцооллоос үзэхэд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад төрд тодорхой хэмжээний ачаалал үүсэхгүй тоо гарч байгаа тул хувилбарыг хялбарчлах боломжийг тооцоолох шаардлагагүй гэж үзлээ.

Сав газрын захиргаад эсвэл сум, дүүргийн Засаг дарга цэвэрлэх байгууламжуудтай болон байгальд шууд хаягдал ус нийлүүлж байгаа аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулах, цэвэрлэх байгууламжууд ус бохирдуулагчийн талаарх мэдээллийг татварт гаргаж өгөхийг ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн төслийн нэмэлт, өөрчлөлтөд;

Аймаг, нийслэлийн байгаль орчны газар хүний үйл ажиллагааны улмаас элэгдэл, эвдрэлд орж, ашиглалтгүй орхигдсон газрыг өөрийн хүч, хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дүгнэлт гаргахаар тус тус тусгасан нь төрийн хүний нөөцийн ачаалал бага зэрэг үүсгэх ба нэмэлт, зардал гаргахгүйгээр шийдвэрлэх боломжтой гэж үзлээ.

3.2. Иргэнд үүсэх зардал

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль, Засгийн газрын холбогдох тогтоолоор холбогдох тогтоолоор хүн ам ус бохирдуулсны төлбөрөөс чөлөөлөгдөхөөр байна. Энэ нь тэдний бохир усны зардалд шууд нөлөө үзүүлэхгүй.

3.2.1 Иргэн, аж ахуйн нэгж

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хүрээнд нэмэлт өөрчлөлт орж байгаа Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр иргэн, аж ахуйн нэгжид зардал үүснэ.

Уурхайн ашиглалт, ой, усны сан бүхий нутгийн хамгаалалтын бүсэд зохих хууль тогтоомж, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгж, байгууллагад төлбөр төлөх үүрэг ноогдож, хамаарч байна гэж үзлээ.

Байгаль орчноо хамгаалах, экосистемийн тогтвортой байдлыг хангахын тулд уурхайн ашиглалт, ой, усны сан бүхий газар нутгийн хамгаалалтын бүсэд зохих хууль тогтоомж, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгж, байгууллагын газрын төлбөрийн хэмжээг нэмэгдүүлэх бодлого баримталж байгаа бөгөөд Монгол улсын нутаг дэвсгэрт өөр бусад ямар ч газар үйл ажиллагаа явуулах эрх нь хуулиараа нээлттэй байна.

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТООЦООЛОЛ

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах эцсийн зорилго төсөвт орлого бүрдүүлэх биш бөгөөд эдгээр онцгой бүс газарт газар эзэмшигч, ашиглагчийн тоог аажмаар хязгаарласнаар экосистемийн тогтвортой байдлыг хангах үндсэн зорилготой. Газрын нэгдмэл сангийн 2016 оны тайлан мэдээ, Засгийн газрын 152 дугаар тогтоолыг үндэслэн тооцоолол хийсэн.

Уурхайн дэвсгэр газар 2016 оны 12 дугаар сарын байдлаар 159143,7 га байгаа бөгөөд хуулинд өөрчлөлт орсноор төсөвт ойролцоогоор нийт 18,1 тэрбум төгрөг төвлөрөх судалгаа байна /Хүснэгт 2/.

№	Аймаг, нийслэлийн нэрс	Уурхайн эдэлбэр газар, га	Одоо төлж буй дундаж төлбөр, га/төг	Нийт төлбөл зохих, төг	Шинээр тогтоогдох дундаж төлбөр, га/төг	Нийт дүн , төг
1	Архангай	7,436.3	16,000.0	118,981,440.0	100000	743,634,000.0
2	Баянхонгор	13.3	16,000.0	212,525.8	80000	1,062,629.0
3	Баян-Өлгий	3,577.4	16,000.0	57,238,720.0	100000	357,742,000.0
4	Булган	5,504.9	16,000.0	88,078,240.0	80000	440,391,200.0
5	Говь-Алтай	3,270.4	16,000.0	52,326,400.0	80000	261,632,000.0
6	Говьсүмбэр	520.3	16,000.0	8,324,800.0	80000	41,624,000.0
7	Дархан-Уул	4,715.1	16,000.0	75,441,600.0	100000	471,510,000.0
8	Дорнод	11,515.8	16,000.0	184,252,640.0	80000	921,263,200.0
9	Дорноговь	33,131.3	16,000.0	530,100,000.0	80000	2,650,500,000.0
10	Дундговь	772.0	16,000.0	12,352,000.0	80000	61,760,000.0
11	Завхан	13.9	16,000.0	222,400.0	80000	1,112,000.0
12	Орхон	4,165.5	16,000.0	66,648,160.0	400000	1,666,204,000.0
13	Өвөрхангай	1,922.1	16,000.0	30,753,600.0	80000	153,768,000.0
14	Өмнөговь	16,371.2	16,000.0	261,939,040.0	80000	1,309,695,200.0
15	Сүхбаатар	2,227.3	16,000.0	35,636,960.0	100000	222,731,000.0
16	Сэлэнгэ	14,837.8	16,000.0	237,404,960.0	80000	1,187,024,800.0
17	Увс	554.1	16,000.0	8,864,800.0	100000	55,405,000.0
18	Ховд	2,130.0	16,000.0	34,080,000.0	100000	213,000,000.0
19	Хөвсгөл	201.3	16,000.0	3,220,800.0	100000	20,130,000.0
20	Хэнтий	3,696.0	16,000.0	59,135,300.0	80000	295,676,500.0
21	Улаанбаатар	4,550.9	16,000.0	72,814,414.4	880000	4,004,792,792.0
22	Нийт дүн	159,143.7		2,546,299,840.2		18,122,013,521.0

2016 оны тайлан мэдээгээр улсын хэмжээнд усны сан бүхий газар эзэмшил, ашиглалтанд нийт 1641,8 га талбай байгаа бөгөөд хуульд өөрчлөлт орсноор улсын төсөвт нийт ойролцоогоор 42,5 сая төг төвлөрөх төлөвтэй байна /Хүснэгт 3/.

Хүснэгт 3

№	Аймаг, нийслэлийн нэрс	Усны сан бүхий газар, га	Одоо төлж буй дундаж төлбөр, га/төг	Нийт төлбөл зохих, төг	Шинээр тогтоогдох дундаж төлбөр, га/төг	Нийт дүн , төг
1	Архангай					
2	Баянхонгор					
3	Баян-Өлгий					
4	Булган	271.0	8,000.0	2,167,760.0	80000	21,677,600.0
5	Говь-Алтай	109.8	8,000.0	878,400.0	80000	8,784,000.0
6	Говьсүмбэр					
7	Дархан-Уул	27.8	8,000.0	222,400.0	100000	2,780,000.0
8	Дорнод					
9	Дорноговь					
10	Дундговь					
11	Завхан	68.2	8,000.0	545,600.0	80000	5,456,000.0
12	Орхон					
13	Өвөрхангай					
14	Өмнөговь					
15	Сүхбаатар					
16	Сэлэнгэ					
17	Төв					
18	Увс					
19	Ховд	38.0	8,000.0	304,000.0	100000	3,800,000.0
20	Хөвсгөл	1,127.0				
21	Хэнтий					
22	Улаанбаатар	0.0072	16,000.0	115.2	880000	6,336.0
23	Нийт дүн	1,641.8		4,118,275.2		42,503,936.0

Ойн сан бүхий газар нийт 84171,5 га талбайд газар эзэмшиж, ашиглаж байгаа бөгөөд хуульд өөрчлөлт орсноор төсөвт 8,6 тэрбум төгрөг төвлөрөх судалгаа байна /Хүснэгт 4/.

Хүснэгт 4

№	Аймаг, нийслэлийн нэрс	Ойн сан бүхий газар, га	Одоо төлж буй дундаж төлбөр, га/төг	Нийт төлбөл зохиx, төг	Шинээр тогтоогдох дундаж төлбөр, га/төг	Нийт дүн , төг
1	Архангай					
2	Баянхонгор					
3	Баян-Өлгий					
4	Булган	469.7	16000	7,515,193.6	80000.0	37,575,968.0
5	Говь-Алтай	-				-
6	Говьсүмбэр					
7	Дархан-Уул					
8	Дорнод					
9	Дорноговь					
10	Дундговь					
11	Завхан	28.7	16000	459,200.0	100000	2,870,000.0
12	Орхон					
13	Өвөрхангай					
14	Өмнөговь					
15	Сүхбаатар					
16	Сэлэнгэ					
17	Төв					
18	Увс					
19	Ховд	284.8	16000	4,557,120.0	100000	28,482,000.0
20	Хөвсгөл	83.084.0	16000	1,329,344,000.0	100000	8,308,400,000.0
21	Хэнтий					
22	Улаанбаатар	304.3	880000	267,789,887.2	880000	267,789,887.2
23	Нийт дүн	84,171.5		1,609,665,400.8		8,645,117,855.2

3.3 Аж ахуйн нэгж буюу хуулийн этгээдэд үүсэх зардал

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр ус бохирдуулагч аж ахуйн нэгж буюу хуулийн этгээд нь өөрийн хаягдал усан дахь бохирдлын хэмжээг хянах, багасгах, хаягдал усаа цэвэрлэн дахин ашиглахын зэрэгцээ бүртгүүлэх, тайлагнах үүргийг хүлээнэ. Аж ахуйн нэгжүүдийг хаягдал усаа төвлөрсөн шугам сүлжээнд нийлүүлж буй, байгальд шууд нийлүүлж байгаа гэж ангилах бөгөөд 2 дахь ангилалд байгальд хаягдал усаа шууд нийлүүлж буй аж ахуйн нэгжүүдийн дотор хот, суурин газрын Цэвэрлэх байгууламжууд хамрагдана.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар аж ахуйн нэгжид зардал үүсэхгүй.

Ус бохирдуулсны төлбөрийн доод хэмжээг хуулийн төсөлд зааснаар умбуур бодис болон органик бодис 50 төг/кг, эрдэс бодис 20 төг/кг, хүнд металл 500 төг/кг болгон бууруулснаар ус бохирдуулсны төлбөр төлөх аж ахуйн нэгжид учрах дарамтыг 2-2.5 дахин бууруулах юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. 2017 он. БОАЖЯ;
2. Монгол Улсын Үндсэн хууль;
3. Хууль тогтоомжийн тухай хууль;
4. Агаарын тухай хууль;
5. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль;
6. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль;
7. Захиргааны ерөнхий хууль;
8. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль;
9. Татварын ерөнхий хууль;
10. Зөрчлийн тухай хууль;
11. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга. 2017 он. БОАЖЯ;
12. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,
13. Усны тухай хууль нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
14. Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл
15. УСУГ-ын 2015, 2016 оны тайлан;
16. УСУГ-ын лабораторийн шинжилгээний дүнгүүд
17. ХСУХАТАУ33-ийн хяналт үнэлгээний тайлан, 2015, 2016 он

